

**ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ
НЭР:**

**ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТЫН АЛБАНД
ХЭРЭГЖИЖ БУЙ ЗАРИМ ЭРХ ЗҮЙН
БАРИМТ БИЧГИЙН НӨХЦӨЛ
БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

**ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ
ТАЙЛАН БИЧСЭН:**

**Ц.АМАРЖАРГАЛ, НИЙГМИЙН
УДИРДЛАГЫН МАГИСТР, ХТХАА-НЫ
МЭРГЭЖИЛТЭН**

Хүний нөөцийн бодлого зохицуулалтын алба/ХНБЗА/ нь эрүүл мэндийн ажилтны төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагааны чиглэлээр дараах эрхзүйн баримт бичгүүдийг баримтлан ажиллаж байна. Үүнд:

1. Эрүүл мэндийн тухай хууль, 2011-05-05
2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, 2016.04.22
3. ЭМС-ын “Журам шинэчлэн батлах тухай” А/337 дугаар тушаал, 2017-09-01
4. ЭМС-ын “Төгсөлтийн дараахь үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” А/184 дүгээр тушаал, 2016-12-15
5. Эрүүл мэнд, спортын сайд, сангийн сайдын хамтарсан “Журам батлах, зардлын жишиг, төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 97/56 дугаар тушаал 2015-03-16

1. Эрүүл мэндийн тухай хууль 2011-05-05

Эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар бүлэг-**Эрүүл мэндийн ажилтны эрх, үүрэг, нийгмийн баталгаа:**

- ✓ Хуулийн 25.13-д “Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон төрийн байгууллага нь төгсөлтийн дараахь сургалт, мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааг зохион байгуулах бөгөөд мэргэжлийн нийгэмлэг, холбооны оролцоог хангана.” гэж заасны дагуу ЭМХТ-ийн Хүний нөөцийн бодлого зохицуулалтын алба нь төгсөлтийн дараахь мэргэшүүлэх болон тасралтгүй сургалтын үйл ажиллагааг мэргэжлийн салбар зөвлөл, мэргэжлийн нийгэмлэг, холбоодын оролцоог ханган 20 сургалт эрхлэх байгууллагатай хамтран зохион байгуулж, удирдлага, мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна. Үндсэн мэргэшлийн 27 чиглэлийн сургалтыг 20, төрөлжсөн мэргэжлийн их эмчийн 82, сувилахуй тусгай мэргэжилтний 32 чиглэлийн сургалтыг 16 сургалт эрхлэх байгууллага зохион байгуулж байна.
- ✓ Журмын 25.16-д заасан “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараахь сургалтын болон мэргэшлийн зэргийн үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам, мэргэшлийн зэрэг олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам, мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам, мэргэшлийн зэргийн болон төгсөлтийн дараахь сургалтыг төгсөгчид олгох үнэмлэх, гэрчилгээний загварыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, төгсөлтийн дараахь сургалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх журам, зардлын жишиг, сургалтын тэтгэлэг олгох шалгуур, тэтгэлгийн хэмжээ, мэргэшлийн зэргийн шалгалтын төлбөр, зардлын жишигийг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” гэсэн заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ажлын алба нь ЭМС-ын “Журам шинэчлэн батлах тухай” А/337, ЭМС-ын “Төгсөлтийн дараахь үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” А/184, Эрүүл мэнд, спортын сайд, сангийн сайдын хамтарсан “Журам батлах, зардлын жишиг, төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 97/56 дугаар тушаалыг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна.
- ✓ Хуулийн 25.17-д “Эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн сан нь эмнэлгийн мэргэжилтний талаархи мэдээллийн лавлагаа болох бөгөөд эмнэлгийн мэргэжилтэн бүр бүртгэлийн хувийн дугаартай байна.” гэсэн заасан боловч Эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн сан бий болоогүй байна. Эрүүл мэндийн сайдын 2018 оны “Журам батлах тухай”/484 дүгээр тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн санг хөтлөх, мэдээллийг шинэчлэх, ашиглах журам”-ыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль

- ✓ Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар бүлгийн 22 дугаар зүйлийн 22.2-т резидент эмчийн эрх үүргийг, 22.3-т резидент эмчийн ажиллах үлгэрчилсэн журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэж заасан.

ЭМС-ын “Журам шинэчлэн батлах тухай” А/337 дугаар тушаалаар батлагдсан журмын 2.5.1.1-д: “Хүний их эмчийн ерөнхий мэргэшил судлал үндсэн мэргэшлийн сургалт нь нэг жил;” гэж заасан нь хуулийн 5 дугаар бүлгийн 22 дугаар зүйлийн 22.2 дах заалтыг хэрэгжүүлэх боломж бүрдсэн байна.

Ажлын алба нь ЭМЯ-ны ТЗУГ-тай хамтран “Резидент эмчийн ажиллах журам”-ын төслийн хэлэлцүүлгийг 5 удаа зохион байгуулж, эмнэл зүйн сургагч багш, сургалтын албаны дарга, арга зүйч, резидент эмч нийт 160 гаруй хүн хамрагдсан. Журмын төсөлд хэлэлцүүлгээр гарсан саналыг тусган, ЭМЯ-ны ТЗУГ-тай хамтран www.mohs.mn цахим хуудасны “Төсөлд санал авч байна” буланд 2019.03.21-ний өдрөөс 1 сар байршуулсан байна.

3. ЭМС-ын “Журам шинэчлэн батлах тухай” А/337 дугаар тушаал

ЭМС-ын “Журам шинэчлэн батлах тухай” А/337 дугаар тушаал нь 5 хавсралттай.

- ✓ Нэгдүгээр хавсралт: “Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам”,
- ✓ Хоёрдугаар хавсралт: “Төгсөлтийн дараахь сургалт эрхлэх байгууллагад олгох гэрчилгээний загвар”,
- ✓ Гуравдугаар хавсралт: Төгсөлтийн дараахь эмнэл зүйн мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалт удирдах эмнэл зүйн сургагч багшид олгох гэрчилгээний загвар”,
- ✓ Дөрөвдүгээр хавсралт: “Төгсөлтийн дараахь сургалт төгсөгчид олгох үнэмлэх, гэрчилгээний загвар”,
- ✓ Тавдугаар хавсралт: “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараахь сургалтын үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх орон тооны бус зөвлөлийн ажиллах журам”,

Энэ тушаалаар батлагдсан журамд төгсөлтийн **дараах сургалтын шинэчлэл өөрчлөлт тусгагдсан. Үүнд:**

1. Журмын 2.1 дах: “Төгсөлтийн дараахь сургалтыг эмнэл зүйн болон эмнэл зүйн бус гэсэн хоёр дэд төрөлтэй байна” заалт нь төгсөлтийн дараах сургалтын орчинг зөв оновчтой бүрдүүлэх боломж бүрдсэн.
2. Журмын 2.5.1.1 дах: “Хүний их эмчийн ерөнхий мэргэшил судлал үндсэн мэргэшлийн сургалт нь нэг жил;” заалт нь 2016 онд батлагдсан Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар бүлгийн 22 дугаар зүйлийн 22.2 дах заалтыг хэрэгжүүлэх боломж бүрдсэн.
3. Журмын 3.4.5 дах: “Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалтын хөтөлбөрт тавигдах дэлгэрэнгүй шаардлагын төслийг боловсруулах, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн хурлаар баталсан дэлгэрэнгүй шаардлагыг сургалт эрхлэх байгууллагад мөрдүүлэх” заалт нь сургалт эрхлэх байгууллагууд мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг олон улсын жишигт нийцсэн байдлаар боловсруулж, мөрдөх суурийг тавьсан байна.

4. Журмын 4.2-д эмнэл зүйн сургалтыг зөвхөн эмнэлгийн тусламж үйлчилгээний байгууллага түшиглэн явуулах, 4.4-д энэ байгууллага нь хоёр ба түүнээс дээш тооны сүлжээнд нэгдэн ажиллана гэж заасан нь төгсөлтийн дараах сургалтын чанарыг сайжруулах сайн талтай.
5. Журмын 8 дугаар зүйлийн 8.1-17-д төгсөлтийн дараах сургалт эрхлэх байгууллагад тавигдах шаардлага, 20 дугаар зүйлийн 1-д Эмнэл зүйн сургалт эрхлэх байгууллагын, 20.2-д эмнэл зүйн бус сургалт эрхлэх байгууллагад тавигдах шаардлагыг үнэлэх аргачлалыг тусгасан нь төгсөлтийн дараах сургалтын орчин, багшлах чадавхийг эхнээс хангалттай бүрдүүлэх улмаар сургалтын чанар сайжрахад нөлөөлнө.
6. Журмын 12 дугаар зүйлд эмнэл зүйн болон эмнэл зүйн бус сургалт удирдах сургагч багшид тавигдах шаардлага, эмнэл зүйн сургагч багшийн үүрэг хариуцлага, Эмнэл зүйн сургагч багшийн сургалтын агуулгыг тусгаж өгсөн нь сургалтыг суралцагчийн оролцоонд тулгуурласан, идэвхитэй арга бүхий байдлаар удирдах, сургалтын хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах аргад суралцах ач холбогдолтой.
7. Гуравдугаар хавсралтад Төгсөлтийн дараахь эмнэл зүйн мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалт удирдах эмнэл зүйн сургагч багшид олгох гэрчилгээний загвар, дөрөвдүгээр хавсралтад Төгсөлтийн дараахь сургалт төгсөгчид олгох үнэмлэх, гэрчилгээний загварыг олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц байдлаар тусгасан.

4. ЭМС-ын “Төгсөлтийн дараахь үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” А/184 дүгээр тушаал, 2016-12-15

Энэ тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараахь үндсэн мэргэшлийн сургалтын чиглэл, индекс”-ийн дагуу 2017 оноос эхлэн нүүр ам судлал 3, анагаах судлал 22, сэргээн засал -1, уламжлалт анагаах ухаан -2, нийт 26 чиглэлээр үндсэн мэргэшлийн сургалтын элсэлтийг ЭМС-ын “Журам шинэчлэн батлах тухай” А/337 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу жил бүрийн 10 сарын 1-нээс, тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараахь төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэл, индекс”-ийн дагуу эмч, эмнэлгийн мэргэжилтний жил бүрийн 04 сарын 01, 10 сарын 01-ны өдрөөс сургалтанд хамруулж хэвшсэн байна.

Энэхүү тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараахь төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэл, индекс”-т нийцэхгүй төрөлжсөн мэргэшлийн зарим сургалтын чиглэл байна. Жишээ нь:

- “Гавал тархины мэдрэлийн мэс засал судлал” чиглэлийг мэдрэлийн мэс засал судлалд чиглэлд шилжүүлсэн нь гэх мэт.

5. Эрүүл мэнд, спортын сайд, сангийн сайдын хамтарсан “Журам батлах, зардлын жишиг, төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 97/56 дугаар тушаал 2015-03-16

Энэ тушаал 4 хавсралттай. Энэ журамд элсэлт төгсөлт, зэргийн шалгалт, багшид олгох хөлсний хэмжээ хэт бага тусгагдсан.

Төгсөлтийн дараахь сургалтын зардлын 5%-ийг ЭМХТ төгсөлтийн дараахь үйл ажиллагаанд зарцуулах тусгасан хэдий ч төгсөлтийн дараахь сургалтын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, хэрэгжилтийг зохион байгуулалтаар хангах, элсэлт төгсөлтийн шалгалтыг

зохион байгуулах, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтын гадаад, дотоод сорил боловсруулах ажлын хөлс олгоход хангалттай биш байгаа нь бүлгийн ярилцлагаас харагдаж байна.

Үр дүн:

1. Эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 25 дугаар заалтын 25.13-16 заалт хангалттай хэрэгжиж байна.
2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар бүлгийн 22 дугаар заалтын 22.2, 22.3 дах заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Резидент эмчийн ажиллах журам, Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журмын боловсруулан ЭМС-нд хүргүүлсэн байна.
3. Ажлын алба нь ЭМС-ын “Журам шинэчлэн батлах тухай” А/337 дугаар тушаалаар батлагдсан батлагдсан “Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, сунгах, хүчингүй болгох журам”-ын дагуу мэргэшүүлэх болон тасралтгүй сургалтын удирдлага, зохион байгуулалт, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. *Журмын 2.5.1.1 дах: “Хүний их эмчийн ерөнхий мэргэшил судлал үндсэн мэргэшлийн сургалт нь нэг жил;”* заалт нь *Журмын 2.5.1.1 дах: “Хүний их эмчийн ерөнхий мэргэшил судлал үндсэн мэргэшлийн сургалт нь нэг жил;”* заалтыг хэрэгжүүлж, Японы олон улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллагын “Анхан болон хоёрдахь шатлалын эмнэлгийн төгсөлтийн дараахь сургалтыг сайжруулах” төслийн дэмжлэгтэй Ерөнхий мэргэшил судлал сургалтын хөтөлбөрийг АШУУИС-ийн багш нартай хамтран боловсруулж, ЭМХЗ-ийн хурлаар батлуулсан байна.
2018-2019 оны хичээлийн жилд Ерөнхий мэргэшил судлал сургалт эрхлэх эрхийг Орхон аймгийн БОЭТ, нийслэлийн Чингэлтэй дүүргийн ЭМТ-д үнэлгээ хийж, сургалт эрхлэх эрх олгожээ. 2018-2019 оны хичээлийн жилд Ерөнхий мэргэшил судлал үндсэн мэргэшлийн сургалтад 20 суралцагч суралцан төгссөн, 2019-2020 оны хичээлийн жилд 25 суралцагч элсэн суралцаж байна.
Японы олон улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллагын “Анхан болон хоёрдахь шатлалын эмнэлгийн төгсөлтийн дараахь сургалтыг сайжруулах” төслийн дэмжлэгтэй сургалт эрхлэх байгууллагын явцын үнэлгээний шалгуур боловсруулан ЭМХТ-ийн Ерөнхий захирлын 2019 оны А/32 дугаар тушаалын хавсралтаар баталж, 2019 онд 12 сургалт эрхлэх байгууллагын сургалтын үйл ажиллагаанд явцын үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлжээ.
Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалтын хөтөлбөрт тавигдах дэлгэрэнгүй шаардлагыг боловсруулж, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн хурлаар 2019.06.03-ны өдөр хэлэлцүүлж, хурлын 02 тоот тогтоолоор батлуулж, мэргэшүүлэх сургалт эрхлэх 20 байгууллагад хүргүүлэн мэргэжил арга зүйн ханган ажилласан байна. Мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн шинэчлэл явагдаж байна.
Эмнэл зүйн сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийг төслийн багтай хамтран сайжруулж, 2019 онд 7 удаагийн сургалтаар 168 эмнэл зүйн сургагч багш бэлтгэж, зурам заасны дагуу үнэмлэх олгосон байна.
4. ЭМС-ын “Төгсөлтийн дараахь үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” А/184 дүгээр тушаалын нэг, хоёрдугаар хавсралтаар батлагдсан мэргэшлийн чиглэлээр мэргэшүүлэх сургалт явагдаж байна.
5. Эрүүл мэнд, спортын сайд, сангийн сайдын хамтарсан “Журам батлах, зардлын жишиг, төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 97/56 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан журмын дагуу тухайн жилийн мэргэшүүлэх, төсрөлтгүй сургалтын захиалга, сургалтын төсөвийн төсөөллийг хийж, ЭМЯ-нд хүргүүлж, ЭМС-ын тушаалаар батлагаажуулж, сургалтыг зохион байгуулж байна.

Тус төв нь Төгсөлтийн дараах сургалтын зардлын 5%-ийг төгсөлтийн дараах үйл ажиллагаанд зарцуулах тусгасан хэдий ч төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, хэрэгжилтийг зохион байгуулалтаар хангах, элсэлт төгсөлтийн шалгалтыг зохион байгуулах, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтын гадаад, дотоод сорил боловсруулах ажлын хөлс олгоход зарцуулан ажиллаж байна.

Зөвлөмж:

1. ЭМС-ын “Журам шинэчлэн батлах тухай” А/337 дугаар тушаалаар батлагдсан батлагдсан “Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, сунгах, хүчингүй болгох журам”-Сургалт эрхлэх байгууллагын эрх үүргийг тодорхой тусгах.
2. Мэргэшүүлэх сургалтын элсэлт төгсөлтийн шалгалтын зохион байгуулалтыг хэт дэлгэрэнгүй байдлаар тусгасан.
3. Журмын 15.17.2-т “Үндсэн мэргэшлийн сургалтад суралцах мэргэжилтэн нь онооны дарааллын дагуу сонгосон аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газартай гэрээ байгуулж, улсын төсвийн зардлаар суралцана.” гэж заасан нь өнөөгийн нөхцөл байдалд зохицохгүй байна. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь тухайн орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах мэргэжилтэнг сонгон гэрээ байгуулдаг ч хэрэгжилтийг сайжруулах
4. Журмын 18.2-т “..... мэргэшүүлэх сургалтын төгсөлтийн шалгалт нь сорил ба дадлага гэсэн хоёр шаттай байх бөгөөд сорилын шалгалтад тэнцсэн тохиолдолд дадлагын шалгалтад орно. Мэргэжил дээшлүүлэх сургалтын хувьд зөвхөн сорилын шалгалт авна.” гэж заасан. Өнөөгийн нөхцөлд бодлогын сорил боловсруулах чадавхи байхгүй байна.
5. Ерөнхий мэргэшил судлал үндсэн мэргэшлийн сургалт, өргөжүүлэх чиглэлээр сургалт эрхлэх байгууллага, аймаг ниймлэлийн эрүүл мэндийн газарт чиглэсэн заалт оруулах
6. Ерөнхий мэргэшил судлал үндсэн мэргэшлийн сургалтыг аймаг дүүргийн Нэгдсэн эмнэлэг, БОЭТ-д түшиглэн зохион байгуулах талаар заалт нэмж оруулах
7. Тухайн жилийн сургалтын төсөвт Эмнэл зүйн сургагч багш бэлтгэх, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулах, үнэлгээ хийх зардлын хэмжээ жил бүр нэмэгдүүлж байх